

ХОЁР ХӨРШ БА МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДЛУУД

*Л.Оюунгэрэл**

Эдийн засгийн аюулгүй байдлын үзэл онол өөрчлөгдөж байгаа нь

Дээрх асуудлыг авч үзэхийн өмнө даяаршлын эрин үед эдийн засгийн аюулгүй байдал гэдэг нь харьцангуй ойлголт болж байгааг юуны өмнө тэмдэглэх хэрэгтэй. Дэлхийн улс орнуудын эдийн засгийн болон нийгмийн үйл явц улам бүр өөр хоорондоо харилцан хамааралтай болж байгаа өнөө үед аль нэг улс эдийн засгаа бүрэн дүүрэн бие даан хөгжүүлэх боломжгүй болсон билээ. Тэгэх тусмаа цөөн хүн амтай, эдийн засгийн хөгжил дорой Монголын хувьд эдийн засаг нь сонгодог утгаараа бүрэн дүүрэн бие даана гэж байхгүй юм. Монголын хувьд бол хоёр хөрш ба дэлхийн эдийн засгаас бүрэн хараат бус болно гэсэн зорилт тавих юм бол мөрөөдлийн шинжтэй болно. Эдийн засгийн аюулгүй байдлын сонгодог үзэл баримтлалаар бол Монголын эдийн засаг өнөөдөр хоёр хөршөөсөө бүрэн хараат байгаа юм. Жишээлбэл, эрчим хүч, шатахууны 80-90 хувийг Оросын Холбооны Улсаас авч байгаа ба гадаад худалдааны хувьд Хятадаас улам бүр хараат болж байна. Хэдийгээр эдийн засгийн аюулгүй байдлын сонгодог үзэл баримтлалыг хуучирсан гэж үзэх болсон ч манайхаас том, хүчирхэг улс гүрнүүд ч хүртэл эдийн засгийн аюулгүй байдлаа сонгодог үзэл баримтлалын дагуу хамгаалсаар байна. Жишээлбэл Оросын Холбооны Улс гэхэд л нефть, байгалийн хий зэрэг эрчим хүчний бодлогоороо дамжуулан бүс нутаг болон дэлхий дахинд улс орныхоо эдийн засгийн ба улс төрийн жин нөлөөг нэмэгдүүлэх чиг баримталж байна. Тэгвэл Хятад улс ч эрчим хүчний түүхий эдийн хэрэгцээ эрс нэмэгдсэн учраас нефть, нүүрс олборлох, экспортлох чиглэлд төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд нь тус дөхөм болох аварга том концернүүдийг байгуулж эхэллээ.

Харин Монголын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд уламжлалт үзэл, онолын үүднээс хандах боломжгүй юм. Энэ нь юуны өмнө манай улсын эдийн засгийн бодит байдалтай холбоотой. Монгол нь дэлхийн хүчирхэг гүрэн байсан түүхтэй ч 1921 оноос эдийн засаг нь гадаадын тусламжтай хөгжиж ирсэн ба 1990-2000 он хүртэл АНУ, Япон, Европын Холбооны гишүүн улсууд, дэлхийн бусад хандивлагч улсуудын тусламж нэн чухал ач холбогдолтой байсан билээ. Харин 2000 оноос эхлэн уул уурхайн баялаг, нэн ялангуяа

* Л.Оюунгэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

дэлхийн зах зээл дээр нүүрс, зэс, алтны үнэ огцом өссөний ачаар Монголын эдийн засаг нь бараг зуугаад жилийн түүхэндээ анх удаа бусдын гар харахгүйгээр улс орныхоо хөгжилд ашигтай хөрөнгө оруулалт хийж үндэсний эдийн засгийн бүтцээ шинэчлэн өөрчлөх түүхэн боломж нээгдэж байна. Гэхдээ монголчууд гадаадын хөрөнгө оруулалтгүйгээр уул уурхайн баялгаа дан өөрсдөө ашиглаж чадахгүй гэдэг нь бас Монголын эдийн засаг дахь гадаад хүчин зүйл чухал хэвээр гэдгийг харуулж байгаа билээ. Тиймээс Монголын хувьд эдийн засгийн аюулгүй байдлаа бэхжүүлнэ гэдэг бол эдийн засгийг хөгжүүлэхдээ аль болохоор өөрийн хүчинд тулгуурлахаас гадна гадаад хүчин зүйлийг монголчуудын эрх ашигт нийцүүлэн бүрэн дүүрэн ашиглах явдал юм. Энэ нь гадаад улс төрийн салбар дахь олон тулгуурт зарчим баримтлаж байгааг эдийн засгийн гадаад харилцаанд хэрэгжүүлнэ гэсэн үг юм. Монголын эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд доорх эн тэргүүлэх хандлагуудыг баримтлах хэрэгтэй болж байна:

1. Монголын эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хийж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх
2. Хоёр хөршийн эдийн засгийн оролцоог тэнцвэржүүлэх,
3. “гурав дахь хөршийн” эдийн засгийн оролцоог тууштай нэмэгдүүлж хоёр хөршийн оролцоотой тэнцвэржүүлэх

Эдгээр хандлагуудыг онолын ч хувьд, практикийн ч хувьд ямагт цугт нь иж бүрнээр авч үзэх ёстой юм. Тийм учраас гуравдахь асуудлыг хөндөхгүй ч энд зориуд цохон тэмдэглэж байгаа билээ.

Монголын эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх асуудал

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд хамгийн чухал зорилт бол эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх явдал юм. Өрсөлдөх чадварыг хөхиүлэн дэмжсэнээр эдийн засгийн бүтцийг зохистой болгож чадна. Монголын эдийн засгийн өсөлт сүүлийн 5 жилд 6-10 хувийн өсөлттэй байгаа нь сайн үр дүн боловч энэ үзүүлэлт нь гол төлөв уул уурхайн салбараас хамааралтай. Өөрөөр хэлбэл уул уурхайн орлого Хятад улсад уул уурхайн түүхий эд – зэс, молибден, алт их хэмжээгээр шаардлагатай байгаа, ойрын арваад жил Хятадад нүүрсийг хэрэглэсээр байх болно гэж таамаглаж байгаа ч Хятадад агаарын бохирдлыг бууруулах зорилгоор ойрын 20 жилд нүүрснээс өөр төрлийн эрчим хүч хэрэглэхийг чухалд үзэж одооноос бодлого, төлөвлөгөөндөө тусгаж байгааг ч бас тооцоолох учиртай. Нэг үгээр хэлэхэд уул уурхайн баялаг бол нэгд, хэзээ нэгэн цагт бүрэн шавхагдаж дуусна, хоёрт, гадаад зах зээл дээрх эрэлт хэрэгцээ, үнээс шууд хамааралтай. Тиймээс Монголын эдийн засгийн

бүтэц дан ганц уул уурхай, мал аж ахуйд дулдуйдаж болохгүй байгаа билээ. Дэлхийн бусад улсын туршлагаас харахад уул уурхайн салбар дахь өндөр ашгаас улбаалан үйлдвэрлэлийн бусад салбар уналтад орж улмаар гадаад валютын ханш өсч, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш буурах үзэгдэл гарч болзошгүй байна. /дани өвчин/ Энэхүү үзэгдлийн гол сөрөг үр дагавар нь үндэсний аж үйлдвэр хөгждөггүй ажээ. Тэр утгаараа уул уурхайн баялгийг худалдан авагчаас бүрэн хараат болдог байна. /ялангуяа цөөн хэдэн улсад экспортолдог бол/ Иймээс Монголын эдийн засгийн шинэ бүтцийг ойрын арваад жилд уул уурхайн баялгаас олох орлогоос хөрөнгө оруулалт хийх замаар төлөвлөж, байгуулж амжихгүй бол эдийн засгийн аюулгүй байдал тун бүрхэг болох магадлалтай. Уул уурхайн түүхий эдийн үнийн өсөлт ойрын 10-15 жил тогтвортой үргэлжилнэ гэж мэргэжилтнүүд тооцоолж байгаа ба чухам энэ хугацаанд Монголын эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хийж дуусгах шаардлагатай байгаа билээ.

Эдийн засгийн бодлогын боловсруулалт ба хэрэгжилт ямар удаан үр ашиггүй байгааг доорх хоёр жишээ маш тод харуулж байна. Ашигт малтмалын Хуулийг хөрөнгө оруулагчид ба Монголын засгийн газар, иргэдэд үр өгөөжтэй байх хувилбараар боловсруулна гэж яриад даруй 4 жил боллоо. Одоо хэлэлцэж байгаа боловч нийгэмд энэ асуудлаар консенсус бий болоогүй хэвээр байна. Мөн түүнчилэн 2002 онд Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай Хууль баталсан ба хойд хил дээр Алтанбулагийн, урьд хил дээр Замын-Үүдийн чөлөөт бүс байгуулна гэж яриад мөн л 6 жил болж байхад өнөөдөр тодорхой үр дүн байхгүй л байна.

Монголын эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ гэдэг бол эдийн засгийнхаа давуу ба сул талуудыг тооцоолж, давуу тал дээрээ түшиглэн эдийн засгийн шинэ салбаруудыг хөгжүүлнэ гэсэн үг юм. Харин өнөөдөр уул уурхайн баялгаас цааш харж сэтгэж чадахгүй байна. Асуудлыг цогцоор авч үзэж дотоодын хөрөнгө оруулалтыг тооцоолж шийдвэрлэхгүй бол уул уурхайгаас олж буй ашгийг үр дүн багатай зүйлд зарцуулж болзошгүй юм. Монголын өрсөлдөх чадварын талаар Монголын засгийн газраас илүү хандивлагч улс орон, байгууллагууд санаа зовниж байна гэлтэй. 1990-2008 онд НҮБХХ, Дэлхийн Банк, АНУ-ын Тусламжийн Агентлаг зэрэг байгууллагууд Монголын эдийн засагт удаа дараа үнэлгээ хийж судалгаа явуулан Монголын төрийн захиргааны байгууллагуудад танилцуулсаар байна. Хандивлагчдын тайланд Монголын эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх талаар олон тооны оновчтой санал, санаачилгууд дэвшүүлдэг билээ. Жишээлбэл, Дэлхийн Банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газраас 2007 онд гаргасан тайланд Монголын хөгжлийг хангахад өрсөлдөх боломжтой салбаруудад мэдээлэл технологи,

агаарын тээврээр зөөх боломжтой махны үйлдвэрлэлийн тодорхой чиглэлүүд, ургамлын гаралтай эмийн үйлдвэрлэл, гоо сайхны бүтээгдэхүүн, жимс, жимсгэний үйлдвэрлэл зэргийг дурьдсан нь бодуштай санаа ажээ. Гадаадын судлаачдын байнга тэмдэглэдэг зүйл бол Монголын давуу тал бол юуны өмнө боловсролтой иргэд гэдэг билээ. Харин сүүлийн хорь шахам жил эдийн засгийн сэтгэлгээнд зонхилж байгаа бүгдийг мөнгөөр хэмжих хандлага арилаагүй цагт боловсролтой иргэдээ хөгжлийн үнэт капитал, эдийн засгийг хурдасгагч, үйлдвэрлэлийн инновацийг хэрэгжүүлэгч гол хүч гэсэн улс төр, эдийн засгийн шинэлэг сэтгэлгээ хөгжиж чадахгүй билээ. Хөгжлийн хэтийн төлвийн талаар гадаад, дотоодын байгууллагуудаас олон чухал санал, санаачилгууд гарч байгаа боловч тэдгээрийг тууштай хэрэгжүүлэх, үндэсний хэмжээний том хөтөлбөр болгон хэрэгжүүлэх, гүйцэтгэгчдийг төлөвлөгөөтэй бэлдэх, санхүүжилтийг тооцоолох ажил ихээхэн дутагдалтай байна. Энэ нь гол төлөв эдийн засгийн шийдвэр гаргах үйл явцыг судалгааны үндсэн дээр гаргах, олон нийтийн дэмжлэгийг зохион байгуулах, үр дүнг сурталчилах зэрэг бизнес, маркетингийн ажлыг төрийн байгууллагууд гардан зохион байгуулах орчин үеийн арга барил дутагдаж байгаатай холбоотой байна.

Монголын эдийн засаг дахь хоёр хөршийн оролцоог тэнцвэржүүлэх зорилт

Монголын эдийн засагт ОХУ, БНХАУ-тай хамтран ажиллах чиглэл бол манай гадаад бодлогын тэргүүлэх чиглэл байсан бөгөөд цаашид ч байх билээ. Монголын эдийн засаг дахь ОХУ ба БНХАУ-ын оролцооны өнөөгийн түвшинг авч үзвэл доорх хандлагууд ажиглагдаж байна.

1. Хуучин социализмын үед хөрөнгө оруулалт хийсэн Монгол-Оросын хамтарсан үйлдвэрүүд Монголын эдийн засгийн гол салбарууд хэвээр байна. Жишээлбэл Эрдэнэт, Улаанбаатар төмөр зам ба Монголросцветмет нийлээд Монголын ДНБ-ий 20 хувийг үйлдвэрлэж байна. Энэ нь нэг талаас Монгол-Оросын эдийн засгийн харилцаа үр ашигтай байгаа мэт харагдавч нөгөө талаас 1990 оноос хойш ОХУ Монголд томоохон хөрөнгө оруулалт хийгээгүй, бас Монголд тэр цагаас хойш томоохон үйлдвэр байгуулаагүйг харуулж байна. ОХУ сүүлийн үед уул уурхайн салбарыг сонирхох болсон нь хоёр орны төдийгүй хөрш гурван улсын хамтын ажиллагаанд шинэ үйл явцын эхлэл болох магадлалтай.

2. Гадаад худалдаа, хятадын иргэд Монголд жижиг бизнес эрхлэх, монголчуудтай хамтран монгол хүний нэрээр газрын зөвшөөрөл ба уул уурхайн лиценз эзэмших зэрэг олон чиглэлд Хятадын оролцоо Оросынхоос давамгайлж байна. Жишээлбэл Монголын нийт бараа эргэлтэнд ОХУ-ын эзлэх хувь 20 орчим хувь

байгаа бөгөөд 2000-2006 онд үндсэндээ нэмэгдээгүй байна. Харин БНХАУ-ын оролцоо Монголын нийт бараа эргэлтэнд 2000-2006 онд 34.78 хувиас 47.7 хувь болж нэмэгдэв.

1990 оноос хойш ОХУ ба БНХАУ-тай Монголын тогтоосон эдийн засгийн хамтын ажиллагааны онцлог нь бүс нутгийн хамтын ажиллагаа зонхилж байгаатай холбоотой. Монголын гадаад худалдааны эргэлтийн дийлэнх хувь ОХУ-ын Байгаль орчмын субъектүүд, БНХАУ-ын ӨМӨЗО-д ногдож байна. Мөн иргэд хоорондын солилцооны дийлэнх хувь ч дээрх бүс нутгийн хамтын ажиллагаанд ногдож байна. Харин 2000 оноос хойш Монголд уул уурхайн салбар эдийн засагт чухал үүрэгтэй болсноос хойших хугацаанд хоёр хөршийн улсын ба хувийн үндэстэн дамнасан том компаниудтай хамтран ажиллах боломж, хэтийн төлөв нээгдэж байна.

Хоёр хөрштэй тогтоосон эдийн засгийн хамтын ажиллагаанд юуны өмнө харилцан ашигтай байх зарчмыг тууштай баримтлах явдал чухал болж байна. 1990 оноос хойш өнөөг хүртэлх харилцаанд Монголд төдийлөн ашиггүй байдал хоёр талын харилцааны аль алинд зонхилж байлаа. Оростой хийх Монголын худалдаа алдагдалтай байгаа бол Хятадтай харилцаж ирэх явцад өрсөлдөх чадварын асуудал хурцаар гарч ирсэн билээ. Монгол, Хятадын харилцаанд иргэд хоорондын харилцаа зонхилж ирсэн нь хувь хүмүүст ашигтай мэт байсан боловч Монголын ноолуурын салбар, цаашлаад барилга, одоо эрүүл мэнд гэх мэт олон салбарын өрсөлдөх чадваргүйг тод харууллаа. Монголын малчид үндсэндээ Өвөр Монголын 600-аад ноолуурын үйлдвэрт түүхий эд бэлтгэгч болж хувирсан ч тэдний амьдрал мэдэгдэхүйц дээшилсэнгүй. Түүнчилэн монголын компаниуд хятад ажилчдыг олноор нь ажиллуулдаг ба тэдний нилээд хэсэг хууль бусаар Монголд үлдэж гар аргаар алт олборлох, эсвэл монгол алт олборлогчдод мөнгөн ус зэрэг химийн бодисыг зөвшөөрөлгүй худалдах гэх мэт улс орны экологийн аюулгүй байдалд ноцтой асуудлууд болж байна.

Тиймээс Монголын эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх зорилттой холбогдож Монгол-ОХУ ба Монгол-БНХАУ-ын харилцаанд шийдвэрлэх ёстой ямар асуудлууд байгааг юуны өмнө дурьдах хэрэгтэй:

ОХУ-ын хувьд:

1. Монгол нь шатахуун, эрчим хүчний эскпортын хувьд ОХУ-аас ихээхэн хамааралтай байдлыг аль болохоор багасгах зорилт тулгарч байгаа билээ. Энэ чиглэлд Монголын засгийн газар тодорхой арга хэмжээ төлөвлөж байгаа бөгөөд 2012 он гэхэд нефтийн үйлдвэр байгуулахаар ажиллаж байна.

2. Саяхан Казахстан улстай эрчим хүчний салбарт хамтран ажиллахаар тохиролцлоо.

БНХАУ-ын хувьд:

1. 90-ээд оны эхэн үед гадаадын хөрөнгө оруулагчийг татах зорилгоор хөрөнгө оруулалтын босгыг 10 мянган ам.доллар гэж тогтоосон учраас БНХАУ-аас олон мянган хятад иргэд үйлчилгээний салбарт жижиг бизнес, уул уурхайн салбарт байгаль орчинд халтай аргаар алт ба бусад эрдэс олборлож байгаад дүгнэлт хийх цаг болжээ. БНХАУ-тай харилцахдаа жижиг бизнестэй бус, улсын том компаниудтай харилцах нь Монголын талд илүү ашигтай. Учир нь улсын ба хувийн жижиг үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэлийн соёл, бараа, бүтээгдэхүүний чанар тэс өөр байдаг. Түүнчилэн олон тооны жижиг худалдаачин, үйлдвэрлэгчидтэй харилцах нь хоёр орны харилцаанд сөргөөр нөлөөлж болох иргэд хоорондын асуудлыг үүсгэдэг.

Монголын эдийн засаг дахь ОХУ ба БНХАУ-ын оролцоог чөлөөт зах зээлийн хууль гээд урсгалаар нь орхих биш, судалгаа шинжилгээний үндсэн дээр тогтоож бодлогод тусгах явдал чухал байна. Яагаад энэ чухал вэ? гэвэл энэ асуудлыг төрийн зохицуулалтгүй орхивол эдийн засгийн үйл явц аяндаа Монголыг Хятадын эдийн засгаас бүрэн хараат байдал руу хөтөлж байгаа билээ. Энэ нь хэнээс ч хамаарахгүй бодит үзэгдэл юм. Дэлхийн эдийн засаг даяарчилагдаж байгаа энэ үед улс үндэстнүүд өөрийн гэсэн дүр төрхөө хадгалан үлдэх, засгийн газрууд үндэстэн дамнасан корпорациудтай өрсөлдөж төр улсынхаа хил хязгаарын хүрээнд эдийн засгийн бодлогоо иргэдийнхээ эрх ашгийн тусын тулд хэрэгжүүлэхийн төлөө чармайн ажиллаж байна. Монголын засгийн газар ч ялгаагүй уул уурхайн салбарын хэтийн төлвийг авч үзэхдээ энэ чиглэлд шинэ санаачилгуудыг эхлүүлээд байна.

Монголын эдийн засагт оролцох хоёр хөршийн оролцоог нэн ялангуяа уул уурхайн салбарт зохицуулах явдал Монголын эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой байх болно. Тиймээс энэ асуудлыг иж бүрнээр судалж бодлого боловсруулах шаардлагатай байна. Харин өнөөдөр уул уурхайн салбар дахь гадаад хүчин зүйлийг ГХЯ болон гадаад бодлогыг хариуцдаг төрийн бусад байгууллагуудын ямар ч оролцоогүй гагцхүү ганц агентлагт, тэр ч байтугай салбарын ганц мэргэжилтэнд даатгаж ирсэн бодлогын алдааг аль болохоор түргэн засах хэрэгтэй байна. Энэ алдаатай бодлогын улмаас өнөөдөр Монголын 22 аймгийн нутаг дэвсгэр дэх 4500 орд газрын лиценз Монголын ба гадаадын /нилээд хувь нь хятадтай хамтрсан/ мэргэжлийн бус жижиг компаниудын мэдэлд очоод байна.

Хоёр хөршийн ба “гурав дахь хөршийн” оролцоог тэнцвэржүүлэхийн тулд уул уурхайн салбарт ашиглалтын тендер зарлахын өмнө нүүрс, зэс молибден, алт, уран, полиметаллын нөөцөө ямар улстай хамтарч ашиглах талаар тодорхой үзэл баримтлал

боловсруулах шаардлагатай байна. УИХ-аар удахгүй батлагдах Ашигт малтмалын шинэ Хуулинд гадаад түншийн асуудал тусгагдахгүй учраас ийм үзэл баримтлал боловсруулах нэн чухал юм. Оюу Толгойн уурхайг Австрали-Их Британийн Рио Тинготой хамтран ашиглах гэж байгаа ба харин бусад уурхайнуудын хувьд аль ч улстай хамтарсан эрдэсийг худалдан авагч нь Хятад байх болно. Олон улсын экспертүүдийн тооцоолсноор Хятадын эрчим хүчний хэрэгцээнд нүүрс – 60 хувь, түүхий нефть – 21 хувь, байгалийн хий – 3 хувь ба цөмийн эрчим хүч - 2 хувь эзэлж байна. Тиймээс Монголын нүүрс ба түүхий нефтийг гол худалдан авагч нь Хятад учраас Таван Толгойн орд газрыг гол хэрэглэгчийн оролцоогүй ОХУ ба “гурав дахь хөршийн” бусад улсын оролцоотой ашиглах нь зүйтэй болов уу? Худалдан авагч үнээ өөрөө тогтоох боломжийг олгохгүй байх нь зах зээлийн наад захын дүрэм билээ. Монголын жижиг компаниуд эрдэс баялгийг дэлхийн зах зээлийн үнээс доогуур маш ашиггүй худалдаж байгаа жишээ олныг дурьдаж болно. Энэ нь тухайн уурхайг ашиглах лиценз монгол иргэний нэр дээр боловч гол хөрөнгө оруулагч нь хятад иргэд байдагтай холбоотой болов уу? Иймэрхүү асуудал хавтгайрсан учраас засгийн газар уул уурхайн салбар дахь төрийн оролцооны асуудлыг үзэл баримтлалын түвшинд авч үзэж байгаа нь нийт монголчуудын эрх ашигт нийцэж байгаа юм.

Харин Хятад улстай нефтийн үйлдвэрлэлийн салбарт хамтран ажиллах нь хоёр улсын аль алиных нь эрх ашигт нийцэж байгаа билээ. Монголын үнэт баялгийн нэг бол уран ба полиметалл юм. Дэлхийн тогтоогдсон ураны нөөцийн хоёр хувь Монголд байгаа ба прогноз судалгаагаар энэ тоо 20 хувь хүрэх бололцоотой гэж үздэг ажээ. Ураны олборлолтыг аль улстай хамтрах нь бас л Монголын эдийн засгийн аюулгүй байдлын асуудалтай холбоотой асуудал юм. Одоогоор ОХУ ба Франц улс уран хамтран олборлох талаар саналаа хэлээд байна. Эцэст нь тэмдэглэхэд Монголын говь ба баруун аймгуудад ихээхэн нөөцтэй полиметаллыг олборлох асуудлыг нарийвчлан судлах хэрэгтэй гэж бодогдож байгаа билээ. Энэ чиглэлд Японтой хамтран ажиллах нь Монголын Дорнод ба Баруун бүсийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой байхаас гадны хоёр хөршийнхөө бүс нутгаас хэтрэхгүй байгаа гадаад эдийн засгийн хамтын ажиллагааг Япон, Казахстан, Өмнөд Солонгос гээд олон оролцогчтой болгосноор Зүүн Хойд Азийн интеграцчлалд бодитой оролцох боломжийг бүрдүүлэх билээ.

Ашигласан материал

1. Common Country Assessment 2004, UN Country team in China, Beijing, p. 21
2. Баабар, Тэс хөндлөнгөөс /Дээрээс?/, Өдрийн сонин, 2008 оны 3 сарын 19